

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2022 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ЭЭЛЖИТ
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

2022 оны 09 дүгээр сарын 30

Улаанбаатар хот

Д/Д	Үүрэг, даалгаврын дагуу хийж, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээг үй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Оноо
Үүрэг, даалгавар-НЭГ: Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг сайтар хангаж, удаашралтай байгаа, хөрөнгө оруулалт шаардагдахгүй ажлуудаа эрчимжүүлж ажиллах. /Нийт байгууллагуудын удирдлагууд/				
1.	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх 2022 оны төлөвлөгөөний хөрөнгө оруулалт шаардагдахгүй ажлуудыг эрчимжүүлж ажиллах тухай нийт 69 дэргэдэх харьяа хэлтэс, албадад дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 3/2323 тоот албан бичгээр чиглэл хүргүүлсэн. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн биелэлт 3 дугаар улирлын байдлаар 85,4%-ийн гүйцэтгэлтэй дүгнэгдэн, 2022 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 3/2222 тоот албан бичгээр тогтоосон хугацаанд Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	70
Үүрэг, даалгавар-ХОЁР: Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ дүүрэг, дүүргийн иргэдтэй хийх уулзалтуудын бэлтгэл ажлыг сайтар хангаж ажиллах. /Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Дүүргийн Засаг дарга/				
2.	Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ 2022 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр Нийслэл, дүүргийн удирдлага, хороодын Засаг дарга, хэсгийн ахлагч нарт “Шинэ сэргэлтийн бодлого Алсын хараа -2050” уулзалтыг зохион байгууллаа. УИХ-аас баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого”, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан үндэсний нэгдмэл үнэт зүйл, үндэсний бахархал, өв соёл, хүний хөгжил, эдийн засаг, засаглал, ногоон хөгжлийн бодлого, нийслэл болон бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын хэрэгжилтийг танилцууллаа. Уулзалтад Нийслэлийн Иргэдийн Хурлын Төлөөлөгчид, хотын удирдлагууд болон дүүрэг, хороодын удирдлага, хэсгийн ахлагч нар нийт 2165 төрийн албан хаагч оролцсоноос дүүргийн хэмжээнд 241 албан хаагч 97.96% -ийн ирцтэйгээр оролцлоо.	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	100

Үүрэг, даалгавар ГУРАВ: Нийслэлийн хэмжээнд өвөлжилтийн бэлтгэл ажлыг сайтар хангах, мэргэжлийн чиг үүргийн байгууллагууд өвлийн их ачааллын үед иргэдийг ус, дулаан, цахилгаан эрчим хүчээр найдвартай хангахад онцгой анхаарах, шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллах.

3.	<p>Дүүргийн хэмжээнд 2022-2023 оны Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд 12 салбарын 118 заалттай төлөвлөгөө боловсруулж, 2022 оны 09 дүгээр сарын байдлаар 92,5 хувьтай байна.</p> <ul style="list-style-type: none"> ➤ Нийтлэг үйлчилгээний газар ОНӨТҮГ- 85% ➤ Эрүүл мэндийн төв -86% ➤ Боловсролын хэлтэс -95% ➤ Онцгой байдлын хэлтэс -90% ➤ ОСНААУГ Хэрэглэгчдэд үйлчлэх төв 6 -82% ➤ ОСНААУГ Хэрэглэгчдэд үйлчлэх төв 7 -79,9% ➤ Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК Чингэлтэй хэрэглэгчдэд үйлчлэх төв -93% ➤ “Чингэлтэй дүүргийн Тохжилт, үйлчилгээ” ХХК -100% ➤ “Найши трейд” ХХК -90% ➤ Гэрэлтүүлгийн ашиглалт үйлчилгээ хариуцсан “Соён дрийм” ХХК -95% <p>Хувийн халаалтын уурын зуухнууд:</p> <ul style="list-style-type: none"> ➤ “Ану сервис” ХХК -95% ➤ “Элбэг дулаан” ХХК -95%-ийн гүйцэтгэлтэй байна. 		Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	70
----	--	--	---------------------------------------	----

Үүрэг, даалгавар ДӨРӨВ: Эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн засвар, орчны тохижилт болон инженерийн шугам сүлжээний ажлуудыг эрчимжүүлж дуусгах, улсын комисст хүлээлгэж өгөх ажлуудаа шуурхай зохион байгуулах. /Нийслэлийн Боловсролын газар, Эрүүл мэндийн газар, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар, Дүүргийн Засаг дарга нар/

4.	<p>Эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн засвар, орчны тохижилт болон инженерийн шугам сүлжээний ажлуудыг эрчимжүүлэх ажлын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> ✓ 4 дүгээр цэцэрлэгийн үндсэн барилгын бохирын 3 худаг бөглөрснийг бүрэн цэвэрлэсэн. ✓ 5 дугаар цэцэрлэг сангийн дотор шугам задарч ус алддаг байсныг засварлаж, дээврийг хэсэгчлэн засварлаж дууссан. ✓ 37 дугаар сургуулийн биеийн тамирын заалны засвар бүрэн дууссан. ✓ 293 дугаар цэцэрлэгийн дээврийг бүрэн засаж дууссан. ✓ 61 дүгээр сургууль дотор сантехникийн 30 м шугам солих ажил хийгдсэн. ✓ 245 дугаар цэцэрлэг тааз засварласан. ✓ 222 дугаар цэцэрлэг борооны ус зайлуулах хоолой засварласан. <p>Мөн дүүргийн Эрүүл мэндийн төвийн салбар Хүүхдийн амбулаторийн дээврийн засварын ажлыг “Дээдсийн жигүүр” ХХК гүйцэтгэж байна. 2022 оны 09 дүгээр сарын 04–ний өдрөөс засварын ажил эхэлсэн бөгөөд 40 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. Төсөвт өртөг нийт 42,3 сая төгрөг, гадна фасадын ажлын тендерийг зарлахад бэлэн болсон.</p> <p>Улсын комисст хүлээлгэж өгөх сургууль, цэцэрлэгийн ажлын хүрээнд нийт 4 ажил байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ➤ 5 дугаар сургуулийн өргөтгөл-90% ➤ 276 дугаар цэцэрлэг, 144 дүгээр сургуулийн цогцолбор барилга-90% ➤ 5 дугаар хорооны цэцэрлэгийн барилга-75% 	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	90
----	--	---	---------------------------------------	----

	➤ 19 дүгээр хорооны цэцэрлэг, бага сургуулийн барилга-70%-ийн гүйцэтгэлтэй байна.			
Үүрэг, даалгавар ТАВ: Сайжруулсан шахмал түлшийг хэрэглэх, ашиглах заавар, зөвлөгөө болон угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлгийг иргэд, олон нийтэд тогтмол мэдээлж ажиллах. /Агаарын бохирдолтой тэмцэх газар, Дүүргийн Засаг дарга нар, “Таван толгой түлш” ХХК, бусад байгууллагууд/				
5.	Галлагааны улирал эхлүүлсэнтэй холбогдуулан дүүргийн гэр хорооллын 7-20, 24 дүгээр хороодын угаарын хийн хордлогод өртөх өндөр эрсдэлтэй айл өрхүүдэд угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэх ажлыг 2022 оны 09 дүгээр сарын 23-ны өдрөөс зохион байгуулан ажиллаж байна. Энэ хүрээнд 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар угаарын хийн хордлогот өртөх өндөр эрсдэлтэй нийт 8106 айл өрх, 43 аж ахуй нэгж байгууллагад 4 төрлийн нийт 13586 зөвлөмж, сайжруулсан түлш хэрэглэх гарын авлагыг тараан ажиллалаа. Мөн дүүргийн болон хороодын цахим хаягт угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээллийг тавьж иргэд олон нийтийг тогтмол мэдээллээр ханган ажиллаж байна.	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	90
Үүрэг, даалгавар ЗУРГАА: 2022 оны төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг жигд хангаж, орлого төвлөрүүлэгч байгууллагууд орлогын тасалдлыг нөхөж, гүйцэтгэлийг хангах ажлаа эрчимжүүлэх. /Нийт байгууллагуудын удирдлагуудад/				
6.	Дүүргийн Татварын хэлтсийн орлогын төлөвлөгөөний гүйцэтгэл 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар: ➤ Дүүргийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө өссөн дүнгээр 15,558.3 сая төгрөг, гүйцэтгэл 8,651.6 сая төгрөг, гүйцэтгэлийн хувь 55.6%, өссөн дүнгээр гүйцэтгэлийн хувь 93.7%-тай байна. ➤ Дүүргийн 6-19 дүгээр хороодын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж буй ААН-үүдийг тоолох ажлыг 9 сард зохион байгуулж гарсан эхний үр дүнгээр 320 гаруй татвар төлөгч ААН, иргэдийг хамруулан бүртгэлцүүлэх ажлыг хийж байна. Нийт 1864 татвар төлөгчийн 6.2 тэрбум төгрөгийн өрийн дүнд нэхэмжлэх хүргүүлэх, 11 Банк, ББСБ-н 1.7 тэрбум төгрөгийн өрийн үлдэгдлийг төлүүлэх тооцооллыг тулгах, татвар торгуулийн 5.0 орчим тэрбум төгрөгийг төлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр байцаагч бүрд өдөрт 10-20 татвар төлөгчийн өр, төлбөрийг барагдуулах чиглэл өгч татварт хамруулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	90
Үүрэг, даалгавар ДОЛОО: Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн дагуу төсвийн зардлын хэмнэлтийг хэрэгжүүлэх, төсвийн сахилга батыг сайжруулж, байгууллагын үргүй зардлыг багасгаж, нийслэлийн өмчийн үр ашгийг дээшлүүлэх, дотоод хяналт шалгалтаа сайжруулж, үр дүнг шаардаж ажиллах. /Нийт байгууллагуудын удирдлагуудад/				
7.	Засгийн газрын 2021 оны 43, 388 дугаар тогтоол, дүүргийн Засаг даргын 2022 оны “Төсвийн үр өгөөж, сахилга хариуцлагыг сайжруулах” тухай А/45 дугаар захирамжийг 2022 оны 4/246 тоот албан бичгээр, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын 2022 оны 203, 204 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж, биелэлтийг хангаж ажиллахыг 4/1596 тоот албан бичгээр, төсвийн жилд төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дүүргийн Засаг даргын 2022 оны 1/1745 тоот албан бичгээр харьяа 69 байгууллагын төсвийн шууд захирагч нарт тус тус хүргүүлж, өдөр тутмын үндсэн баримтаар хяналт тавин ажилласан.	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	90

Үүрэг, даалгавар НАЙМ: Ерөнхий боловсролын сургуулийн орчинд сурагчид гэмт хэрэг, хэв журмын зөрчил болон зам, тээврийн осолд өртөхөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах ажлуудаа эрчимжүүлэх. /Нийслэлийн Цагдаагийн удирдах газар, Замын цагдаагийн газар, Нийслэлийн Боловсролын газар, Дүүргийн Засаг дарга нар/

8.	<p>“Хичээл эхэллээ” ерөнхий арга хэмжээний хүрээнд ерөнхий боловсролын 29 сургууль, 54 цэцэрлэгийн ойр орчимд 9 чиглэлд 32 алба хаагч хичээл эхлэх, тарах цагуудад /07:30-09:30, 12:00-14:00, 16:00-18:00/ сургуулийн ойр орчимд сурагчдыг гэмт хэрэг, зөрчилд өртөж хохирох, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор Улаан загалмайн нийгэмлэг, Хороодын нийтийн эргүүл, Хүүхэд хамгаалагч нартай хамтарч эргүүлийн үүрэг гүйцэтгэн ажилласан.</p> <p>Дүүргийн Ерөнхий боловсролын 23, 24, 50, 5, 149, 72, 17, 138, 39, 117, 49 дүгээр сургууль, “Олонлог”, “Олонлог эгээ”, Бадмаараг зэрэг сургуулиудын 6-12 ангийн 247 бүлгийн 10924 сурагчдад “Тодорхой төрлийн гэмт хэргийн талаар ойлголт гэмт хэрэг үйлдсэнээр учрах хор уршиг”, “халаасны хулгай”, “Үе тэнгийн дээрлэхэлд”, “Архи тамхины хор хөнөөл”, “Хүүхдийн эрх ба үүрэг” сэдвээр анги тус бүрд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх яриа таниулга хийн, 1-5 дугаар ангийн сурагчдад зориулсан “Сэргийлэгч хүү зөвлөгч охины зөвлөмж” видео хичээлийг сурагчдад үзүүлэх талаар дээрх сургуулиудын захиргаанд хүлээлгэж өгч ажилласан.</p> <p>Ерөнхий боловсролын сургуулийн 23, 24, 50, 5, 149 дүгээр сургуулиудад давхардсан тоогоор нийт 165 өсвөрийн сэргийлэгч бүлгэмийн гишүүд, сургуулийн эргүүлд үүрэг гүйцэтгэж байгаа 452 эцэг эх, асран хамгаалагч нартай уулзаж, мэргэжил арга зүйн зөвлөгөөг 20 удаа өгч, “Сургуулийн эргүүл”-ийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор 202214021, 61, 117,72, 17, 57, 49, 39, 37 дугаар сургуулийн “Өсвөрийн сэргийлэгч” бүлгэмийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор 2022 оны 28л-2а/5993 дугаартай зөвлөмжүүдийг хүргүүлсэн.</p> <p>Хичээл эхэллээ ерөнхий арга хэмжээний хүрээнд дүүргийн Цагдаагийн газраас Баасан гариг бүр нийт 52 чиглэлд 104 алба хаагч, 4 удаа нэгдсэн эргүүл, хяналт шалгалт хийн, явган эргүүлийн үүрэг гүйцэтгэж гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил арга хэмжээг зохион байгуулан ажилласан.</p> <p>Дүүргийн нутаг дэвсгэрт дэх Ерөнхий боловсролын нийт 8 сургууль, 17 цэцэрлэг ойр орчим явган хүний гарц 25 цэгт 50 алба хаагч хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган 3 ээлжээр үүрэг гүйцэтгэн ажилласан. "Хичээлийн шинэ жил хүүхдийн аюулгүй байдал" уриан дор Хайлаастын зам 139, 72, 84, 50, 5 дугаар сургуулиудын дэргэдэх явган хүний гарц дээр хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх аюулгүйн зөвлөмж, тараах материалыг 540 жолоочид тараан ажилласан.</p>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	90
----	---	---	---------------------------------------	----

ДАРГА

Н.БАТСҮМБЭРЭЛ

ТАНИЛЦСАН: НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

П.БАЯНБААТАР

ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА

М.НАВЧАА

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН

Ж.ДУЛМАА

НЭГТГЭСЭН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН

Х.ТУЯА